

**УЛСАД КОВИД 19 ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ,
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ (P175730)**

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭД
НЭЭЛТТЭЙ БОЛГОЖ, САНАЛ АВЧ БАЙНА**

Дэлхийн банкны санхүүжилттэй ЭМЯ-ны хэрэгжүүлж буй “**Монгол улсад Ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах**” төслийн Байгаль Орчин, Нийгмийн Удирдлагын (БОНУ) зорилго нь байгаль орчин, нийгмийн (ОН) болзошгүй эрсдэл, нөлөөллийг Дэлхийн Банкны байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ), түүнчлэн Байгаль орчин, нийгмийн стандартад (ОНС)-д нийцсэн эсэхийг үнэлж, эрсдэл нөлөөллийг бууруулахад оршино.

БОНУ-ын зорилтууд: (а) төслийн санал нь байгаль орчин ба нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг үнэлэх, тэдгээрийг бууруулах арга хэмжээг дэвшүүлх; (б) байгаль орчин, нийгмийн төлөв байдлын урьдчилсан үнэлгээг хийх, үйл ажиллагааг хянах, батлах, хэрэгжүүлэх журам бий болгох; (в) төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг удирдах, хянах, шаардлагатай зохих үүрэг, хариуцлагыг тодорхойлж, тайлагнах үйл явц тоймлох; (г) БОНУ-ын зүйл заалтыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, чадавхийг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлох; (д) олон нийтийн хэлэлцүүлэг хийх, төслийн баримт бичгийг ил тод болгох, төслийн үйл ажиллагаатай холбоотой аливаа гомдлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн механизмыг шийдэх; ба (е) БОНУ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг тооцож гаргах зэрэг болно. БОНУХ нь нийгмийн ядуу, эмзэг бүлгийн иргэд төслийн үр ашгийг хүртэх боломжийг хангах зарчим, тодорхой үйл явцыг ч мөн багтаасан.

Банк/Ассоциаци ба Зээлдэгч/Хүлээн авагч харилцан тохиролцсоны дагуу төслийн хэрэгжилтийн явцад энэхүү БОНУ-г шинэчлэн өөрчилж болох ба Төслийн бүтцийн өөрчлөлт, Байгаль орчин, Нийгмийн Хариуцлагын Төлөвлөгөө (БОНХТ), төслийн гүйцэтгэлд хийсэн үнэлгээний дагуу арга хэмжээ авах, урьдчилан төсөөлөөгүй нөхцөл байдал үүссэн зэргийг харгалзан байгаль орчин, нийгмийн удирдлагад холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж болно.

Байгаль орчин, Нийгмийн Удирдалгын баримт бичгийн төслийг олон нийтэд нээлттэй болгож бөгөөд та бүхэн санал ирүүлж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье.

Санал авах хугацаа: 2021 оны 2-р сарын 1

Санал ирүүлэх хэлбэр:

Цахим шуудан: piu@ehp.mn

Утас: Төслийн ажилтан: А. Энжаргал 77077793

FB: Цахим эрүүл мэнд

Вэб хуудас: <http://ehp.mn>

Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Олимп 5, Аюуд тауэр 11 давхар 1103 тоот

**УЛСАД КОВИД 19 ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ,
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ (P175730)**

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ

(Хураангуй)

Энэхүү Байгаль Орчин, Нийгмийн Удирдлагын (БОНУ) Дэлхийн Банкны Бүлгийн санхүүжилттэй *Монгол улсад Ковид-19 вирустай тэмцэх яаралтай тусламжийн төслийг Цар Тахлын Үеийн яаралтай тусламжийг санхүүжүүлэх хэрэгслээс (ЦТҮЯТСХ) дэмжих төсөл (P174571)* ба Эрүүл Мэндийн Яамны (ЭМЯ) оролцоотойгоор Цар Тахлын Үеийн Яаралтай Тусламжийг Санхүүжүүлэх Хэрэгслээс нэмэлт санхүүжилт авсан энэхүү төслийн (цаашид “Төсөл” гэх) үйл ажиллагааны хүрээлэн буй орчин ба нийгмийн зохистой байдлыг нягтлан хянах ажлыг дэмжих зорилгоор боловсруулсан болно. Олон Улсын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк болон Олон Улсын Хөгжлийн Ассоциаци (цаашид “Банк/Ассоциаци” гэх) тус төсөлд санхүүжилт олгохоор зөвшөөрсөн байна.

БОНУ -ний зорилго нь төслийн хүрээлэн буй орчин ба нийгмийн (ОН) болзошгүй эрсдэл, нөлөөллийг Дэлхийн Банкны орчин ба нийгмийн хүрээ (ОНХ) ба Орчин ба нийгмийн стандартад (ОНС) нийцсэн эсэхийг үнэлж, эрсдэл нөлөөллийг бууруулахад оршино. БОНУ-ний тодорхой зорилтууд нь: (а) санал болгож буй төслийн орчин ба нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг үнэлэх, тэдгээрийг бууруулах арга хэмжээг санал болгох; (б) орчин ба нийгмийн байдлын урьдчилсан үнэлгээг хийх, үйл ажиллагааг хянах, батлах, хэрэгжүүлэх журам бий болгох; (в) төслийн үйл ажиллагаатай холбоотой орчны ба нийгмийн асуудлуудыг удирдах, хянахад шаардлагатай зохих үүрэг, хариуцлагыг тодорхойлж, тайлагнах үйл явц тоймлон гаргах; (г) БОНУ-ний зүйл заалтыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, чадавхийг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлох; (д) олон нийтийн хэлэлцүүлэг хийх, төслийн баримт бичгийг ил тод болгох, аливаа гомдлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн механизмыг шийдэх; ба (е) БОНУ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг тооцож гаргах зэрэг болно. БОНУ нь нийгмийн ядуу, эмзэг бүлгийн иргэд төслийн үр ашгийг хүртэх боломжийг хангах зарчим, тодорхой үйл явцыг дурдсан болно.

Банк/Ассоциаци ба Зээлдэгч/Хүлээн авагч харилцан тохиролцсоны дагуу төслийн хэрэгжилтийн явцад энэхүү БОНУ-г шинэчлэн өөрчилж болох бөгөөд Төслийн бүтцийн өөрчлөлт, Орчин ба нийгмийн амлалтын төлөвлөгөө (ОНАТ) төслийн гүйцэтгэлд хийсэн үнэлгээний дагуу арга хэмжээ авах, урьдчилан төсөөлөөгүй нөхцөл байдал үүссэн зэргийг харгалзан орчны ба нийгмийн удирдлагад зохих өөрчлөлтийг тухай бүр оруулж болно. Ийм тохиолдолд Зээлдэгч/Хүлээн авагч нь ЭМЯ-аараа дамжуулан Банк/Ассоциацитай тухайн өөрчлөлтийг хэлэлцэн тохиролцох ба тухайн өөрчлөлтийг ОНАТ-нд шинэчлэн тусгаж оруулна. Банк/Ассоциаци ба Зээлдэгч/Хүлээн авагч ЭМЯ-аараа дамжуулан албан ёсны гарын үсэг бүхий албан бичгээр харилцан ОНАТ-нд оруулах өөрчлөлтийг харилцан тохиролцсоныг баримтжуулна. Зээлдэгч/хүлээн авагч нь ЭМЯ-аараа дамжуулан шинэчлэгдсэн БОНУ-г цаг тухайд нь олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Төсөл өөрчлөгдөх, урьдчилан төсөөлөөгүй нөхцөл байдал үүсэх, эсвэл төслийн хэрэгжилтийн явцад төслийн гүйцэтгэлийн улмаас эрсдэл, нөлөөллийн нөхцөл байдал өөрчлөгссөн зэрэг тохиолдолд Зээлдэгч/Хүлээн авагч нь шаардлагатай тохиолдолд тухайн эрсдэл, нөлөөллийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилтыг гаргаж ажиллана.

Төслийн тодорхойлолт

Монгол Улс нь COVID-19 цар тахлын дэгдэлтийн эрсдэл өндөртэй байгаа тул энэхүү Төслийг COVID-19 санхүүжилтээр дэмжихээр сонгосон байна. Тус Төслийн хамрах хүрээ, бүрэлдэхүүн хэсгүүд нь COVID-19 Удирдах зөвлөлийн албан бичгийн Хавсралт 2-т дурдсан стандарт бүрэлдэхүүн хэсгүүдийг ашигласан, COVID-19 Түргэвчилсэн Санхүүжилтын Хэрэгслийн шалгуурыг бүрэн хангасан юм. Энэхүү Төсөл нь эрүүл мэндийн үйлчилгээг сонгосон газруудад сайжруулах зорилгоор эрүүл мэндийн мэдээлэл, цахим эрүүл мэндийн шийдлүүдийг интеграцчилах, ашиглалтыг сайжруулах зорилготой Монгол улсын Цахим Эрүүл Мэндийн Төсөл (P131290) зэрэг эрүүл мэндийн салбарын урт хугацааны хөгжлийн үйл ажиллагааг дэмжсэн төсөл юм.

COVID-19 Тэргэвчилсэн Санхүүжилтын Хэрэгслээр дамжуулан үе шаттай хариу арга хэмжээ авахыг санал болгож байна. Айл өрх, бизнес эрхлэгчид болон улсын төсөвт COVID-19 цар тахлын үзүүлж буй эдийн засгийн нөлөөлөлд хариу арга хэмжээ авахад зайлшгүй дэмжлэг шаардлагатай боловч Дэлхийн Банкнаас эрүүл мэндийн чиглэлээр авах хариу арга хэмжээг нэн тэргүүнд дэмжих хандлагыг баримталж байна. Эхний алхам бол Түргэвчилсэн Санхүүжилтын Хэрэгслээр олгосон санхүүжилтын дийлэнх хэсгийг COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбоотой яаралтай бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авахад чиглэсэн эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд зориулах болно. COVID-19 цар тахлын үед авах хариу арга хэмжээний нэг томоохон бэрхшээл бол эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн бэлэн байдал, хүртээмж (үнэ) юм. Дэлхийн Банк хамтран удирдаж буй дэлхийн Цар Тахлын үеийн Хангамж Нийлүүлэлтийн Сүлжээ (ЦТҮХНС) нь цар тахлын үеийн хариу арга хэмжээнд чухал ач холбогдолтой эмнэлгийн бүтээгдэхүүний жагсаалтыг гаргажээ. Цаашид ажлын хэсэг ЭМЯ-тай хамтран Дэлхийн Банкны санхүүжилтээр худалдан авах боломжтой барааны жагсаалтыг гаргахын тулд энэхүү жагсаалтыг Монгол улсын нөхцөлд тохируулан өөрчилж гаргана. Түүнчлэн эрүүл мэндийн тогтолцоо сул, олон жилийн турш хөрөнгө оруулалт хийгдээгүй, орхигдсон байна. COVID-19 цар тахлын хэцүү төвөгтэй нөхцөл байдлын улмаас өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг эрүүл мэндийн салбарын тогтолоо хангаж чадах түвшинд хүрэхийн тулд тоног төхөөрөмж худалдан авах зэргээр чадавхийг бэхжүүлэхэд даруй хөрөнгө оруулах шаардлагатай байна. Эдийн засгийн үйл ажиллагаа, бизнес, ард иргэдийн амьжиргааны хэвийн байдал улам бүр алдагдах магадлал өндөр байна. Улс орнуудтай зөвлөлдөх замаар санхүүжилтийн хэрэгслүүд бий болж байгаа учраас санхүүжилтын бусад хэрэгслүүдийг ашиглан дэмжлэг авах хувилбарыг судалж байна.

COVID-19 цар тахалтай тэмцэх явдал Монгол Улсын Засгийн газрын нэн тэргүүний зорилт байгаа учраас ирээдүйд гарч болзошгүй нийгмийн эрүүл

мэндийн онцгой байдлын үед эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг бэхжүүлэхэд тус Төсөл анхаарна. Иймд энэхүү Төсөл нь эрсдлийн үеийн харилцаа холбоо, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог хангах үндэс суурийг бий болгоход хөрөнгө оруулах зэрэг COVID-19 цар тахлын дэгдэлтэнд хариу арга хэмжээ авах нэн яаралтай хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх болно. Түүнчлэн эмнэлэгт хандах өвчтөнүүдийн тоо өсөхийн хирээр тэдэнд хүртээмжтэй үйлчлэх, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор эрүүл мэндийн тогтолцооны хүрээнд ялангуяа томоохон эмнэлгүүд, аймгийн төвүүдэд эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээний дутагдалтай байдлыг судалж шийдвэрлэхэд тусална.

COVID-19 коронавирусын дэгдэлтийн эсрэг хариу арга хэмжээ авахад нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа талаар Монгол Улсын Засгийн газраас (ЗГ) албан ёсоор хүсэлт гаргасан байдаг. Сангийн сайд COVID-19 цар тахлын эсрэг вакцин худалдаж авахад зориулан Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн (ОУХА) Хямралын Үед Хариу Арга Хэмжээ Авахад Дэмжлэг Үзүүлэх Хөтөлбөрийг ашиглах хүсэлтээ 2020 оны 9-р сарын 23-нд илгээсэн байна. Санал болгож буй нэмэлт санхүүжилт (НС) нь цар тахлын эсрэг эрүүл мэндийн өргөжүүлсэн хариу арга хэмжээний нэг хэсэг болох юм. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар үндсэн том төслийн нийт санхүүжилтийн 25.9 хувийг санхүүжүүлээд байна. Үндсэн төсөл батлагдсанаас хойш (2020 оны 4-р сарын 2) COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах, тухайлбал коронавирусын эсрэг вакцин гарсан зэрэг томоохон өөрчлөлт гарсан учраас Монгол Улсад үүссэн нөхцөл байдлыг харгалзан нэмэлт санхүүжилтын хэрэгцээ шаардлага их байна. Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ), Дэлхийн Банктай нягт зөвшилцөж хандивлагч байгууллагуудын уялдаа холбоо, зохицуулалтыг хариуцан ажиллаж байна. Одоогийн байдлаар Дэлхийн Банк нь COVID-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлж буй нь батлагдсан цорын ганц хандивлагч байгууллага юм. Иймд Монгол Улсад цар тахлын эсрэг тогтвортой, цогц хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэхэд Дэлхийн Банкны оролцоо, хамтын ажиллагааг үргэлжлүүлэх нь туйлын чухал юм.

Нэмэлт санхүүжилт нь COVID-19 цар тахлын эсрэг бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг бэхжүүлэхэд чиглэсэн Монгол Улсын засгийн газрын хүчин чармайлтыг дэмжихээс гадна ирээдүйд нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг сайжруулах үндсэн төслийн хамрах хүрээг өргөжүүлэхэд тусална. Нэмэлт санхүүжилтын үндсэн зорилтууд нь COVID-ын эсрэг вакцины тэгш хүртээмжтэй, хямд өртөгтэй байх боломжийг хангах, вакцинжуулалтын системийг сайжруулж, үндсэн төслийн хүрээнд салбарын бэлэн байдал, хариу арга хэмжээг цаашид бэхжүүлэх замаар Монгол улсад вакциныг үр дүнтэй түгээж хамруулахад туслах явдал юм.

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд

Бүрэлдэхүүн хэсэг 1: COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ба ба цар тахлын эсрэг хариу арга хэмжээ (Нийт 2.5 сая ам доллар COVID19 Түргэн Санхүүжүүлэх Хэрэгсэл (ТСХ)): Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь COVID-19 цар тахлын тархалтыг удаашруулж, хязгаарлах, цаашид нийгмийн

эрүүл мэндийн онцгой байдлын үед бэлэн байдлыг сайжруулахад оршино. Нэгдмэл харилцаа холбоо, зан үйлийг өөрчлөхөд дэмжлэг үзүүлж оролцох, эсрэг тохиолдлыг идэвхтэй илрүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, "Нэг эрүүл мэндийг" дэмжих зохих платформыг бий болгох, нийгмийн эрүүл мэндийн өнөөгийн болон ирээдүйн онцгой байдлын үед ажиллах эрүүл мэндийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх замаар дээрх зорилгыг биелүүлэх юм. Тус бүрэлдэхүүн нь дөрвөн дэд бүрэлдэхүүн хэсэгтэй:

- 1.1: Эрсдэлийн талаарх харилцаа холбоо ба олон нийтийн оролцоо
- 1.2: Хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх
- 1.3: Хүний нөөцийн хөгжил
- 1.4: Нэг Эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлэх

Бүрэлдэхүүн хэсэг 2: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх (Нийт 23.75 сая ам доллар, үүнээс 9.95 сая ам долларыг COVID-19 ТСХ-ээс, 13.8 сая ам долларыг ОУСБХБ-наас) Тус бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь эрэлт огцом нэмэгдсэн тохиолдолд боломжит хамгийн сайн үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд эрүүл мэндийн зайлшгүй тусламж үйлчилгээг бэхжүүлэхэд оршино. Түүнчлэн өвчний ерөнхий нөлөөллийг багасгахын тулд нийгэмд өвчилсөн хүмүүст байнгын дэмжлэг үзүүлэх юм. Эмнэлгийн оновчтой тусламж үзүүлэх, хүний амь насыг аврах зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, өвчтөн болон эрүүл мэндийн ажилтнуудад учрах эрсдлийг хамгийн бага байлгахад чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцооны бэлэн байдлын төлөвлөлт гаргахад тусалцаа үзүүлнэ. Сонгосон эмнэлгүүдэд төрөлжсөн цэгүүдийг байгуулах, эмчилгээний удирдамжийг хэвлэн нийтлэх, эмнэлгийн халдвар хамгааллыг сайжруулах арга хэмжээ авах, хог хаягдлын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хүчилтөрөгч хүргэх тогтолцоо, эм зэрэг эмчилгээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт бүтээгдэхүүнийг худалдан авах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар эмнэлзүйн тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлнэ. Эмнэлэгт тусгаарлан ажиглах тасаг байгуулах замаар тухайн газарт нь тусгаарлан хязгаарлалт хийх нөхцлийг бүрдүүлж дэмжинэ. Эрүүл мэндийн байгууллагуудад халдварын хяналтын талаар өргөн хүрээтэй сургалт, арга хэмжээ зохион байгуулна.

COVID-19 цар тахлын дэгдэлт нь хэвтүүлэн эмчлэх буюу амбулатороор үйлчлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ихээхэн саад учруулж байгаа тул эрүүл мэндийн чухал үйлчилгээ үзүүлэх, өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж ажиллахад туслах зорилгоор сонгосон эрүүл мэндийн байгууламжуудийг засан сэргээж, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ. Иймд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх хүчин чармайлт нь сонгосон эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн болон лабораторийн тоног төхөөрөмж, хувь хүний хамгаалах хэрэгсэл, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн сорил тестээр хангахад чиглэнэ. Монгол Улсын Засгийн газар нь COVID-19 халдвартай өвчтнүүдийг эмчлэхээр хүлээн авах эмнэлэг болгож хэд хэдэн эрүүл мэндийн байгууллагуудыг оноосон байна. Үүнд: i) Анагаахын их сургуулийн сургалтын эмнэлэг; ii) Улаанбаатар хотын Перинатологийн Төв; iii) Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг; iv) бүх аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Хэрэгжилтийн удирдлага, хяналт-шинжилгээ ба үнэлгээ. (0.65 сая ам доллар, COVID-19 ТСХ): Тус Төсөлд одоо хэрэгжиж буй Цахим эрүүл мэндийн төслийн ТХН-ийн ажилтнууд ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт ур чадавх, туршлага бүхий мэргэжилтэн ажиллуулна. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд урьдчилан сэргийлэх болон бэлэн байдлыг хянах, үнэлэх, эмнэлзүйн болон нийгмийн эрүүл мэндийн судалгааны чадавхийг бэхжүүлэх, улсын хэмжээнд хамтран болон харилцан суралцах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд шаардлагатай тохиолдолд төслийн хөрөнгө оруулалтын явц, үр ашиг, өгөөж, ашиглалтын талаар хөндлөнгийн гуравдагч талын хяналт хийлгэх ажлыг дэмжиж болно.

Бүрэлдэхүүн хэсэг 4: Онцгой байдлын тохиолдолд яаралтай тусламж үйлчилгээний хариу арга хэмжээ (ОБЯТҮХАХ) (0 сая ам доллар): Тодорхой шалгуурыг хангасан хямрал, онцгой байдлын үед энэ Төсөл нь тухайн хямрал, онцгой байдалд нэн даруй, үр дүнтэй хариу арга хэмжээ авахад хувь нэмрээ оруулна. Төслийн хүрээнд гарч болзошгүй тодорхой хэрэгцээ шаардлагаас хамааран хөрөнгө төвлөрүүлэх боломжтой тул тус бүрэлдэхүүн хэсэгт тэг өртөгийг төсөвлөв.

Нэмэлт санхүүжилтээр дараах үйл ажиллагааг санхүүжүүлж хэрэгжүүлнэ: 1) улсын хэмжээнд COVID-19 цар тахлын эсрэг вакцинцуулах үер олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, "вакцины талаар мэдлэгтэй болгох", вакцинд итгэх итгэлийг бий болгох, томоохон зорилтот бүлгийг COVID-19 цар тахлын эсрэг вакцинаар вакцинжуулахтай холбоотой худал хуурмаг мэдээ мэдээллийг багасгахад чиглэсэн вакцинжуулалтын талаархи эрсдлийн үеийн харилцаа холбоо, олон нийтэд таниулан сурталчлах үйл ажиллагаа; 2) ДЭМБ-ын Шударга хуваарилалтын хүрээнд тулгуурлан вакциныг түгээж, вакцинжуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах, вакцин тариулсан иргэдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, вакцин тариулсны дараах сөрөг нөлөөг бүртгэх хяналт-шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) системийг боловсруулах үйл ажиллагаа; 3) үйлчилгээг илүү шинэлэг хэлбэрээр явуулах, дасан зохицох, өргөжүүлэх чиглэлээр орон нутгийн олон нийтийн байгууллагуудыг татан оролцуулах, олон нийтийг дайчлан оролцуулах төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагаа; 4) COVID-19 вакцинжуулалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт явуулах, хүний нөөцийг бэлтгэх, дайчлах үйл ажиллагаа; 5) COVID-19 вакцин худалдан авах; 6) шаардагдах агуулах, айгууламж, хүйтэн сүлжээг шинэчлэх, WASH болон орчны эрүүл мэндэд чиглэсэн бага хэмжээний барилга байгууламжийн ажил гүйцэтгэх зэрэг болно. Төлөвлөсөн бүх ажлыг энэхүү БОНУ-ний Хүснэгт 2.1-д тайлбарлав.

Дэлхийн Банкны хүрээлэн буй орчин ба нийгмийн холбогдох стандартууд Төсөлтэй холбоотой хүрээлэн буй орчин ба нийгмийн эрсдлийг төслийн нэмэлт санхүүжилтийн хүрээнд хийгдэх ажлуудын үзүүлэх нөлөөллийн хамт "Их" гэж ангиллаа. ДБ-ны Орчин ба нийгмийн хүрээний (ОНХ) орчин ба нийгмийн 10 стандартын (ОНС) 6 нь энэхүү Төсөлд хамааралтай гэж үзлээ. Үүнд: ОНС1 Хүрээлэн буй орчин ба нийгмийн эрсдэл ба нөлөөллийн үнэлгээ, удирдлага, ОНС2 Хөдөлмөрийн ба ажиллах нөхцөл, ОНС3 Нөөцийн үр ашиг ба бохирдлоос урьдчилан сэргийлэх, удирдах; ОНС4 Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй

байдал, ОНС7 Уугуул иргэд /Саб-Сахарын өмнөд хэсгийн Африкийн түүхэн уламжлалт нутгийн иргэд ба ОНС10 Оролцогч талуудын оролцоо, мэдээллийг ил тод болгох. БОНУ нь халдварт өвчний хяналт, эмнэлгийн хог хаягдлын удирдлагын чиглэлээр Монгол улсын хэмжээнд тавигдах шаардлага болон олон улсын протоколыг харгалзан үзлээ.

ДББ-ийн Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын (ОЭМАБ) удирдамж нь "эрүүл мэндийн байгууллагууд", "хог хаягдлын удирдлага", "аюултай материалын удирдлага", "барилга угсралт ба ашиглалтаас гаргах" зэрэг асуудалтай холбоотой COVID-19 цар тахлын үед баримтлах ёстой ДЭМБ-ийн гаргасан удирдамжтай (Хавсралтаас үзнэ үү) тодорхой хэмжээгээр хамааралтай юм.

Дэлхийн Банкны ОНС-аас гадна тус Төсөл нь Хүрээлэн буй орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, Олон улсын аж үйлдвэрийн сайн туршлагын удирдамж, болон COVID-19 цар тахлын үеийн удирдлагын талаархи ДЭМБ-ын минимум зааварчилгаа, хүрээлэн буй орчныг хамгаалах тухай холбогдох бусад зохицуулалтын хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой. Холбогдох хууль тогтоомжид Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хууль, Дархлаажуулалтын тухай хууль, Хатуу хог хаягдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон Эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлын удирдлагын тухай холбогдох тогтоолууд, Эрүүл мэндийн байгууллагууд, вакцин түгээн дархлаажуулах төлөвлөгөөнд ИРС баримтлах тухай үндэсний удирдамж зэрэг хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Хүрээлэн буй орчин ба нийгмийн эрсдэл ба нөлөөлөл

Төсөл нь хамрах хүрээ, цар хүрээний хувьд үндэсний хэмжээнд хэрэгжинэ. Тус төслийн хүрээнд бүтээн байгуулалтын томоохон ажил хийгдэхгүй. Зөвхөн сумдын эрүүл мэндийн төвүүдэд WASH байгууламж буюу ус, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байгууламж барих, ХӨСҮТ-ийн Хүйтэн агуулахыг өргөтгөх зэрэг бага хэмжээний барилгын ажил хийгдэнэ. Энэхүү COVID-19 санхүүжилтээр барих барилгыг зөвхөн нийтийн эзэмшлийн газарт байгаа барилгуудыг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх учраас газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэх нөлөө үзүүлэхгүй. Түүнчлэн зэрлэг байгалийн ан амьтан, тусгай хамгаалалттай газар, соёлын дурсгалт газруудад нөлөөлөл, эрсдэл учрахгүй. Гэвч COVID-19 цар тахлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах лабораторийн үйл ажиллагаа нь (тоног төхөөрөмж, урвалж/химийн бодис) эмнэлгийн болон ерөнхий хог хаягдлыг зайлуулахтай холбоотой хүрээлэн буй орчин, нийгэмд тодорхой хэмжээний нөлөө үзүүлж болзошгүй бөгөөд урьдчилан сэргийлэх протоколыг дагаж мөрдөөгүй тохиолдолд COVID-19 вирус тархаж болзошгүй юм.

Лаборатори, хорио цээрийн бүс, тусгаарлан ажиглах байр, шалган нэвтрүүлэх постоос (эм, хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж) гарах эмнэлгийн хог хаягдал, химийн бодисын хаягдал (үүнд ус, урвалж, халдвартай материал гэх мэт) нь хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд ихээхэн нөлөө үзүүлж болзошгүй, ялангуяа COVID-19 вирусын халдварыг дамжуулах магадлалтай. Төслийг үр өгөөжийг хүртэж буй эмнэлгийн байгууллага/лаборатори тус бүр ДЭМБ-ын

COVID-19-ийн нөхцөл баримтлах зааварчилгаа, эрүүл мэндийн байгууллагуудад халдвараас урьдчилан сэргийлэх, хяналт тавих үндэсний удирдамж болон бусад олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн энэхүү БОНУ-нд тодорхойлсон шаардлага, эрсдэл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг дагаж мөрдөх шаардлагатай юм. Улмаар сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх эсвэл нөлөөллийг бууруулахын тулд Халдварыг хянах хог хаягдлын удирдлагын төлөвлөгөөг (ХХХХУТ) боловсруулж мөрдөх нь зүйтэй.

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх ихэнх үйл ажиллагааг эрүүл мэндийн лабораторийн ажилтнууд, өөрөөр хэлбэл Монгол Улсын Засгийн газрын төрийн албан хаагчид, үүнд эмнэлгийн эрүүл мэндийн бус үйлчилгээний ажилтнууд (бичиг хэргийн ажилтан, жолооч гэх мэт), мэргэжлийн зөвлөх, гэрээт гүйцэтгэгчид хэрэгжүүлнэ. Эдгээр ажилчдын гол эрсдэл нь COVID-19 (эсвэл бусад халдварт өвчин) -ийн халдвар авах явдал юм. БОНУ-ын Хөдөлмөрийн удирдлагын журамд (ХУЖ, Хавсралт 3-ыг үзнэ үү) эрүүл мэндийн байгууллагад нэвтрэн ороход үүсэх эдгээр эрсдлийн тухай тодорхойлсон бөгөөд ажилчдад халдвар хамгааллын хяналттай холбоотой сэрэмжлүүлэг өгөх, ажилчдыг хамгаалах журам; бүх ангиллын ажилчдад тэдний дагаж мөрдөх ёстой журмын талаар нэн даруй, тогтмол сургалт явуулах; хувийн хамгаалалтын хэрэгслийг (ХХХ) ашиглах, Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын (ХАБЭА) хамгаалалтыг бүрэн хангах тухай сургалтыг зохион байгуулсан байна. Түүнчлэн, Төсөл нь COVID-19 цар тахлын үед авах хариу арга хэмжээг ДЭМБ-ын хамгийн сүүлийн үеийн удирдамжтай тогтмол уялдуулж ажиллана.

Оролцогч Талуудын Оролцооны Төлөвлөгөө нь (ОТӨТ, Хавсралт 4-ийг үзнэ үү) олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ялангуяа олон нийтийн газар хоорондын зай барих, өндөр эрсдэлтэй хүн ам зүй, өөрийгөө ажиглан тусгаарлах дэглэм, албадан тусгаарлагдах хорио цээрийн дэглэмийн талаархи мэдээллийг түгээх зорилгоор олон нийт, ард иргэдтэй өргөн хүрээнд ажиллана. Төсөл нь иргэдтэй харилцах мэдээлэл харилцааны материалыг бүх бүлгийн хүмүүст, ялангуяа ядуу, эмзэг бүлгийнхэн авч танилцаж болохуйц, тэдэнд тохирсон ойлгомжтой энгийн формат, хэлбэрээр боловсруулж бэлтгэхийг хичээнэ.

Төслийн бусад эрсдлүүд нь Бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэл (БМХ), Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) ба Хүүхдийн эсрэг хүчирхийлэл (ХЭХ) зэрэг байх бөгөөд эдгээр эрсдлийг бууруулах арга хэмжээг БОНУ, Хөдөлмөрийн удирдлагын журам, болон ёс зүйн дүрэмд (ЁЗД) тусгасан болно. Ялангуяа тус улсын эрүүл мэндийн салбарт ажиллагсдын дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг учраас жендэрийн асуудлыг төслийн бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдэд чухалчлан харгалзаж үзлээ.

Вакцины чанар, вакцинд хамруулах иргэд эсвэл зорилтот бүлгийг сонгох, төслөөс хамааралтай нөлөөлөл нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан эмзэг, ядуу иргэд эсвэл бүлэгт харьцангуйгаар нөлөөлөх эрсдэл; хөгжлийн нөөц, төслийн үр өгөөжийг хүртэх явцад ялангуяа эмзэг, ядуу бүлгийн иргэдийг ялгаварлан гадуурхах, алагчлан үзэх эрсдэл зэргийг БОНУ-ын нөлөөллийг бууруулах арга хэмжээнд тусгасан болно. Эрүүл мэндийн байгууламжууд нь COVID-19 цар тахал зэрэг бүхий л халдварт өвчний дэгдэлтийн үед хүний эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай аюулгүй цэвэр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг хангасан байна.

ЭМЯ нь БОНУ-ээс гадна энэ чиглэлээр нөлөөллийг бууруулах тодорхой арга хэмжээг боловсруулах шаардлагатай юм. Эдгээр асуудлаар нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон бусад эрсдлийг БОНУ-нд дэлгэрэнгүй орууллаа.

Орчин ба нийгмийн байдлыг урьдчилан үнэлэх

Урьдчилан үнэлгээ хийх зорилго нь: (i) үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл, эрсдэлтэй байж болзошгүй эсэхийг тодорхойлох; болон (ii) нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээг тодорхойлоход оршино. Яливаа сөрөг нөлөөлөл, эрсдэлтэй үйл ажиллагааны хувьд тухайн нөлөөллийг бууруулах арга хэмжээг үйл ажиллагааны хэрэгжилтэнд тусган оруулсан байна. Жишээлбэл, орчны болон нийгмийн удирдлагын зохих төлөвлөгөөг боловсруулж, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж, тайлагнан ажиллана.

Мониторинг, Хяналт ба Тайлагнах

Төсөл Хэрэгжүүлэх Нэгж (ТХН) нь оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагаа, аваар осол, гомдлын бүртгэл зэрэг мэдээллийг агуулсан (гэвч үүгээр хязгаарлагдахгүй) төслийн орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын (ОНЭМАБ) гүйцэтгэлийн талаарх мониторингийн тайланг тогтмол бэлтгэж, Дэлхийн Банкнд илгээнэ.

ЭМЯ-ны ажлын хэсэг нь нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Эрүүл Мэндийн Яамны харъяа Нийгмийн Эрүүл Мэндийн Газар нь БОНУ/ОНУТ-ний хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг төслийн улирал тутмын тайланд тусган мэдээлэх үүрэгтэй.

Хэрэгжүүлэлтийн зохицуулалт ба хариуцлага

Монгол улс дахь COVID-19 цар тахлын үеийн зохицуулалт. Улсын Онцгой Комисс (УОК), ОБЕГ, ЭМЯ, болон бусад байгууллагууд. УОК нь улсын хэмжээнд COVID-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны салбар хоорондын зохицуулалтыг удирдан чиглүүлнэ. Эрүүл Мэндийн Яам нь холбоотой эрүүл мэндийн салбарын хүний нөөц, чадавхийг бэхжүүлэх, тандалт судалгаа хийх, эмчлэх, оношлох, олон нийтэд зориулсан мэдээлэл, харилцаа холбоо, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн материалыг тараах зэрэг COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулж, удирдан зохион байгуулна.

Гамшгаас Хамгаалах Тухай Хуулиар (2017 оноос хойш хэрэгжиж байгаа) Онцгой Байдлын Ерөнхий Газар болон УОК-д Монгол Улсын Засгийн газар болон бүс нутгийн онцгой байдлын комиссуудаар дамжуулан онцгой байдлын үед баримтлах бодлого, арга хэмжээний талаар зааварчилгаа өгч чиглүүлэх эрхийг олгожээ. УОК-ын чиглэл удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль ёсны дагуу хэрэгжүүлэх нь COVID-19 цар тахлын үеийн гамшгаас

хамгаалах удирдлагыг нэгдмэл, төвлөрсөн байдлаар удирдах боломжийг олгож байна.

Чадавхийг бэхжүүлэх

Эрүүл мэндийн салбар нь онцгой байдлын үед халдвараас урьдчилан сэргийлэх ба хянах, эрүүл мэндийн хог хаягдлын удирдлага, харилцаа холбоо, эрсдлийн удирдлага ба олон нийтийн оролцоог хангах чиглэлээр ажиллаж ирсэн туршлагатай. Ихэнх улс орнуудын хувьд COVID-19 цар тахлыг оношлох шинжилгээ хийх лабораторт халдварын эрсдлийг хэрхэн удирдах, COVID-19-ын эмчилгээг хорио цээр, тусгаарлалтын төвүүд хэрхэн явуулах, ялангуяа хог хаягдлыг хэрхэн удирдах талаарх ноу-хауг эрүүл мэндийн мэргэжилтнүүд төдийлөн дэлгэрэнгүй мэддэггүй байх магадлалтай байсан учраас COVID-19 цар тахалтай холбоотой эрсдлийг удирдах чадавхи томоохон сорилт болжээ. Түүнчлэн COVID-19 цар тахлын үед үүссэн олон нийтийн нийгмийн асуудалтай хэрхэн харьцах, ямар арга хэмжээ авах зэрэгтэй холбоотой харилцаа холбооны үйл явц нь ялангуяа хөл хорионы дэглэм нь дэлхий нийтийн хувьд түгээмэл хэрэглэж буй үйл явц болж байна. Төслийн хүрээнд эдгээр чухал санаачлагыг дэмжих, ДЭМБ-ын удирдамжийн дагуу эдгээр асуудлаар олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэхэд чиглэсэн олон улсын туршлагад тулгуурлан ихээхэн хэмжээний санхүүжилт хийх, сургалт явуулах, чадавхийг бэхжүүлэх ажлууд хийгдэх юм. Мөн чадавхийн хувьд дутмаг байгаа асуудлаа цаашид тодорхойлох, төслийн саналын хүрээнд гүнзгийрүүлсэн арга хэмжээ авах ажлыг хэрэгжүүлнэ.

Зөвлөлдөх үйл явц ба оролцогч талуудын оролцоо

Төсөл нь төслийн хэрэгжилтийн хугацаанд олон нийтэд мэдээлэх, зөвлөлдөх зэрэг оролцогч талуудын оролцоог хангах хөтөлбөрийг тодорхойлсон Оролцогч Талуудын Оролцооны Төлөвлөгөө (ОТӨТ) бэлтгэж, зөвлөлдсөн болно. Түүнчлэн төслийн оролцогч талуудтай харилцах харилцаа холбооны стратегийг тодорхойлж, төслийн талаарх санал хүсэлтээ илэрхийлэх, гомдол гаргах механизмыг танилцуулсан юм. ОТӨТ нь дараахи зорилт бүхий цаашид өөрчлөн шинэчилж байх ажлын баримт бичиг юм:

- Төслийн оролцогч бүх талууд, тэдний хувьд нэн тэргүүний чухал асуудлууд, санааг нь зовоосон асуудлуудыг нь тодорхойлж, төсөлд тэдгээрийг тусгах арга замыг хянан баталгаажуулах;
- Оролцогч талуудтай мэдээллийг хүртээмжтэй, утга агуулгатайгаар солилцох, харилцах стратегийг тодорхойлох;
- Оролцогч талуудтай зөвлөлдөх журам, арга зүй болон зөвлөлдөх үйл явцыг баримтжуулах, оролцогч талуудаас санал сэтгэгдэл авах стратегийг тодорхойлох;
- Хүртээмжтэй, нутаг орны соёлд нийцсэн, шуурхай хариу арга хэмжээ авдаг гомдол барагдуулах механизмыг бий болгох, ба
- Төслийн нөлөөлөлд хяналт мониторинг хийхэд оролцогч талуудын оролцоог хангах стратеги боловсруулах

ДЭМБ ба НҮБ-ын Хүүхдийн Сан нь Монгол улс COVAX хөтөлбөр¹ болон түүний вакцинцуулалтын хуваарилалтын төлөвлөгөөнд хамрагдах хүсэлтээ гаргахад тусалж чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Цаашид хэрэгжилтийг дэмжих, чадавхийг бэхжүүлэхэд эдгээр байгууллагууд салшгүй чухал үүрэг гүйцэтгэсээр байх болно. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй суурин төлөөлөгчийн газар, чадварлаг мэргэжилтнүүд, ЭМЯ-тай ялангуяа эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн түүхэн хамтын ажиллагааг эргэн харахад эдгээр байгууллагууд энэ дэмжлэгийг үзүүлэх онцгой байр суурийг эзэлдэг юм.

Гомдол барагдуулах механизм

Гомдол барагдуулах механизм (ГБМ) нь төслийн БОНУ ба Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө (ОТОТ)-ний нэг хэсэг бөгөөд өргөдөл, гомдлыг цаг тухайд нь, үр дүнтэй, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор байгуулагдсан болно. Орон нутгийн иргэд, хүрээлэн буй орчин, эсвэл тэдний амьдралын чанарт сөргөөр нөлөөлж буй талаар төсөлтэй холбоотой гомдол гаргаж болно. Мөн оролцогч талууд санал, зөвлөмжөө ирүүлж болно. ГБМ нь аливаа гомдол маргааныг харилцан ярилцаж шийдвэрлэх зохих арга хэмжээг авах бөгөөд шүүхэд хандах хэрэгцээ шаардлага үүсэхээс зайлсхийж ажиллана. Өргөдөл гомдлыг хот ба аймгуудын нэгдсэн эмнэлгийн түвшинд, улсын хэмжээнд өргөдөл гомдлыг хүлээн авах тусгай дугаарын утсаар хүлээн авах зэргээр ЭМЯ-наас байгуулсан Өргөдөл гомдлыг барагдуулах хороо шийдвэрлэнэ.

Төсөв

БОНУ-г хэрэгжүүлэх зардлыг орчин ба нийгмийн хянан шалгах арга хэмжээг боловсруулах, сургалтад хамруулах болон цаашид тодорхойлох бусад арга хэрэгсэлд зориулан зарцуулна. Тодорхой орчны удирдлагын төлөвлөгөө шаардлагатай газруудад зориулсан Орчин ба Нийгмийн Стандарт (ОНС) боловсруулах болон орчин ба нийгмийн холбогдох бүхий л хяналт шалгалтын тайлан бэлтгэх үүрэгтэй зөвлөх(үүд)-ийг авч ажиллуулахад хөрөнгө шаардлагатай. Хяналт мониторинг хийх, сургалт явуулах зорилгоор албан томилолтоор явах зардлыг мөн тодорхойлсон болно. Эдгээр бүх ажил, санаачилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлын урьдчилсан тооцоо 230,000 доллар байна.

БОНУ-д (жишээ нь халдварыг хянах гэх мэт) заасан зорилгыг биелүүлэх, эрсдлийг удирдах арга хэмжээний талаар төслийн үйл ажиллагаанд олон дахин давхардуулж дурдсан байгааг тэмдэглэх нь зүйтэй. Төслийн төсвийн сайшаахуйц хэсгийг БОНУ-д дурьдсантай ижил төстэй үйл ажиллагаанд,

¹ COVAX нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Тахлын Бэлэн Байдлын Шинэчлэлийн Эвсэл /CEPI/, Дэлхийн Вакцинжуулалт, Дархлаажуулалтын Холбоо /GAVI/-ны хамтран удирдаж буй COVID-19 цар тахалтай тэмцэх арга хэрэгслийн хүртээмжийг хурдасгах “ACT Accelerator” санаачилгын вакцины үндсэн тулгуур юм. Тус хөтөлбөрийн зорилго нь COVID-19 цар тахлын эсрэг вакциныг бий болгох, үйлдвэрлэх үйл явцыг хурдасгах, вакциныг гарган авсны дараа бүх улс орнуудад тэгш шударгаар хуваарилах хүртээмжийг хангахад оршино. <https://www.gavi.org/covax-facility>

тухайлбал сургалт, лабораторийн аюулгүй ажиллагаа, мэдээлэл түгээх ажилд зарцуулах ажээ. Дэлхийн Банкнаас санхүүжүүлэхээр идэвхжүүлсэн COVID-19 цар тахлын үед Онцгой байдлын тохиолдолд яаралтай тусламж үйлчилгээний хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсэг (ОБЯТҮХАХ) нь бусад хөтөлбөр төсөлтэй параллель үйл ажиллагааг хэрэгжүүлэх учраас зардлыг хэмнэхийн тулд ЭМЯ-наас хэрэгжүүлж буй бусад үйл ажиллагаатай уялдуулан энд төсөвлөсөн зардлын тооцоог дахин хянан өөрчлөх нь зүйтэй.